

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

20... оны ... сарын ....-ны өдөр

Дугаар.....

Улаанбаатар хот

**Журамд нэмэлт, өөрчлөлт  
оруулах тухай**

Цагдаагийн албаны тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.12 дахь хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1.Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/121 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Олон нийтийн цагдаагийн таних тэмдэг, хөдөлмөрийн аюулгүй байдлын тусгай хувцас хэрэглэх журам”-ын 1.7 дахь хэсгийн “Нутаг дэвсгэр” гэсний өмнө “Алба, нэгж,” гэж, 2.2.1 дэх заалтын “Хувийн дугаар, цусны бүлэг:”-ийн “тухайн” гэсний дараа “алба, нэгж,” гэж, 5.2 дахь хэсгийн “байдалд” гэсний дараа “алба, нэгж,” гэж тус тус нэмсүгэй.

2.Мөн журмын 2.2 дахь хэсгийн 2.2.1 дэх заалтын “Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын индекс:”-ийг дор дурдсанаар өөрчилсүгэй.

Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын индекс:

Алба, нэгж, нийслэлийн дүүргийн нэр	Индекс	Аймгийн нэр	Индекс	Аймгийн нэр	Индекс
Тээврийн цагдаагийн алба	10	Архангай	20	Завхан	30
Багануур	11	Баян-Өлгий	21	Орхон	31
Багахангай	12	Баянхонгор	22	Өвөрхангай	32
Баянгол	13	Булган	23	Өмнөговь	33
Баянзүрх	14	Говь-Алтай	24	Сүхбаатар	34
Налайх	15	Говьсүмбэр	25	Сэлэнгэ	35
Сонгинохайрхан	16	Дархан-Уул	26	Төв	36
Сүхбаатар	17	Дорноговь	27	Увс	37
Хан-Уул	18	Дорнод	28	Ховд	38
Чингэлтэй	19	Дундговь	29	Хөвсгөл	39
				Хэнтий	40

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд бөгөөд Стратеги, бодлого, инновац, хөгжлийн албаны дарга (цагдаагийн хурандаа О.Ганбат)-д даалгасугай.

4.Тушаалыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА,  
БРИГАДЫН ГЕНЕРАЛ

Т.СҮХБОЛД